

СУДАЛГААНЫ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

20... оны ... дүгээр
сарын ...-ний өдөр

№

Улаанбаатар хот

Нэг талаас: “.....” ХХК-ийг төлөөлж,
..... овогтой /цаашид “Захиалагч” гэх/
нөгөө талаас: “.....” ХХК-ийг төлөөлж, Судалгааны албаны ахлах судлаач
..... /цаашид “Гүйцэтгэгч” гэх, хамтад нь “Талууд” гэх/ нар дараах нөхцлийг
харилцан тохиролцож, энэхүү “Судалгааны ажил гүйцэтгэх гэрээ” /цаашид “Гэрээ” гэх/-г
байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь Захиалагчийн захиалгын дагуу Улаанбаатар хот,
..... дүүрэгт баригдах “.....” барилгын төслийн Техник эдийн
засгийн үзүүлэлт /цаашид “ТЭЗҮ” гэх/-ийг боловсруулах ажлын хүрээнд холбогдох
судалгаа шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэх, төлөвлөлтийн болон санхүү, хөрөнгө
оруулалтын чиглэлээр санал зөвлөмж боловсруулах, Захиалагч нь тогтоосон
хугацаанд Гүйцэтгэгчид ажлын хөлсийг төлөхтэй холбогдон талуудын хооронд үүсэх
эрх зүйн харилцааг зохицуулна.
- 1.2 Судалгааны ажлын үр дүнд бий болсон аливаа судалгааны баримт материал, шинэ
санал, санаачлага зэрэг нь талуудын хамтын өмч байна.
- 1.3 Энэхүү гэрээний хавсралтууд нь гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд гэрээний нэгэн
адил хүчинтэй байна.
- 1.4 Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэх ажлын жагсаалтыг энэхүү гэрээний Хавсралт №1-ээр
баталсан болно.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1 Энэхүү гэрээ нь талууд гэрээнд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан
өдрөөс эхлэн 201.. оны .. дугаар сарын ...-ний өдрийг хүртэл үргэлжлэх бөгөөд талууд
гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж дуусах хүртэл хүчин төгөлдөр байна.

ГУРАВ. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- 3.1 Гүйцэтгэгчийн ТЭЗҮ боловсруулах ажлын хөлс нь нийт
/...../ төгрөг байна.
- 3.2 Захиалагч нь энэхүү гэрээ байгуулагдсан өдөр ажлын хөлсний урьдчилгаа төлбөрт
гэрээний 3.1-т заасан үнийн дүнгийн хувьтай тэнцэх хэмжээний ажлын хөлс буюу
..... /...../ төгрөгийг төлөх бөгөөд үлдэгдэл төлбөрийг
дараах хуваарийн дагуу төлж барагдуулна.
- 3.3

ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1 Гүйцэтгэгч нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:
 - 4.1.1 Гэрээний 3.2-т заасан хуваарийн дагуу ажлын хөлс төлөхийг шаардах;



- 4.1.2 ТЭЗҮ боловсруулахад Захиалагчийн зүгээс шаардагдах мэдээлэл, судалгаа, тайлбар, тодорхойлолт, холбогдох бусад баримт бичгийг бүрэн хэмжээгээр, чөлөөтэй, шуурхай, үнэ төлбөргүй авах;
- 4.1.3 Шаардлагатай тохиолдолд барилгын талбайд очиж, судалгаа, шинжилгээ хийх боломжоор хангахыг шаардах.
- 4.2 Гүйцэтгэгч нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
 - 4.2.1 ТЭЗҮ-ийг Захиалагчаас өгсөн удирдамж, зааварт нийцүүлэн Захиалагчийн санал, санаачлагыг тусган, боловсруулах;
 - 4.2.2 Гэрээгээр тохирсон ажлуудыг мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэн, баримт бичгийг англи, монгол хэл дээр боловсруулж, хүлээлгэн өгөх;
 - 4.2.3

ТАВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1 Захиалагч нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:
 - 5.1.1 Ажлын явцад болон дууссаны дараа гэрээний Хавсралт №1-д заасан ажлуудын гүйцэтгэлд хяналт тавих;
 - 5.1.2 ТЭЗҮ боловсруулах ажлын хүрээнд баримт бичгийг англи, монгол хэл дээр боловсруулж, хүлээлгэн өгөхийг шаардах;
 - 5.1.3
- 5.2 Захиалагч нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
 - 5.2.1 ТЭЗҮ боловсруулахад өөрийн зүгээс шаардагдах мэдээлэл, судалгаа, тайлбар, тодорхойлолт, холбогдох бусад баримт бичгийг Гүйцэтгэгчид бүрэн хэмжээгээр, чөлөөтэй, шуурхай, үнэ төлбөргүй өгөх;
 - 5.2.2 Шаардлагатай тохиолдолд барилгын талбайд очиж, судалгаа, шинжилгээ хийх боломжоор Гүйцэтгэгчийг хангах;
 - 5.2.3

Үргэлжлэл бий /4х/